



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/116/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг:zayag@audit.gov.mn</p> <p>Аудитор:Ц.Алтантуул Утас: 91195554 Цахим хаяг : tuul9565@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.22 № 1303/1411
танай _____ -ны № _____ -т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА М.ҮРЖИНХАНД-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

45.3 сая төгрөгийн гүйлгээг аккруэль сууриар хөтлөөгүй, бараа материалын тайланд тусгаагүй, 195.5 сая төгрөгийн ковидийн бараа материалыг шаардлагатай газруудад цаг хугацаанд нь хүргэж ажиллаагүй зэрэг зөрчил нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.6; Төсвийн тухай хуулийн 26.1 дэхь заалтууд болон санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, ангилал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

013022093

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular official stamp of the State Audit Agency of Mongolia is placed over the signature. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТЫН АГЫН ГЭРЭГ" (State Audit Agency of Mongolia) and "АУДИТЫН АГ" (Audit Agency). The signature is written in black ink over the stamp.

Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>400,233,816.78</u>	<u>846,354,293.69</u>
33	АВЛАГА	23,370,743.23	17,066,195.90
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	23,370,743.23	12,066,195.90
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	5,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	376,593,909.40	829,288,097.79
351	Түүхий эд материал	311,939,842.46	520,897,183.84
35110	Тусгай зориулалттай материал	94,907,048.58	229,406,045.58
35130	Эм боох материал	217,032,793.88	291,491,138.26
354	Хангамжийн материал	64654066.94	308390913.95
35410	Бичиг хэргийн материал	1,477,700.00	1,109,500.00
35420	Аж ахуйн материал	10,764,370.00	8,142,425.00
35440	Түлш, шатах тослох материал	2,225,549.71	1,155,861.90
35450	Барилгын засварын материал	12,183,900.01	9,028,900.01
35470	Бусад хангамжийн материал	38,002,547.22	288,954,227.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,057,329,352.03</u>	<u>1,074,491,969.96</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,057,329,352.03	1,074,491,969.96
392	Биет хөрөнгө	1,014,100,352.07	1,031,323,670.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	722,262,850.00	722,262,850.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-30,591,180.45	-32,630,592.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	196,462,238.60	177,962,238.60
39204	Хуримтлагдсан элэгдэл	-52,539,704.90	-64,602,175.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	223,064,379.56	234,848,008.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,703,654.92	-39,009,303.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,002,018.14	90,702,018.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,856,593.96	-58,209,373.38
393	Биет бус хөрөнгө	43,228,999.96	43,168,299.88
39301	Програм хангамж	810,500.00	810,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,500.04	-336,200.12
39303	Бусад биет бус хөрөнгө	42,694,000.00	42,694,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,457,563,168.81</u>	<u>1,920,846,263.65</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>950,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	950,000.00
413	Өглөг	00.00	950,000.00
4136	Бусад өглөг	00.00	950,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	950,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,457,563,168.81</u>	<u>1,919,896,263.65</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,457,563,168.81	1,919,896,263.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	394,748,008.66	394,748,008.66
51101	Өмч: - төрийн	394,748,008.66	394,748,008.66

512	Хуримтлагдсан үр дүн	400,545,997.19	862,879,092.03
51210	Өмнөх үеийн үр дүн	400,545,997.19	400,545,997.19
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	462,333,094.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	662,269,162.96	662,269,162.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,457,563,168.81	1,920,846,263.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/Төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,178,417,473.50	10,933,478,938.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	374,391,095.50	6,351,659,922.49
120	Нийтлэг татварын бус орлого	374,391,095.50	6,295,386,914.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	374,391,095.50	6,295,386,914.94
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	202,156,358.00	6,295,386,914.94
122	Тусламжийн орлого	00.00	56,273,007.55
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	56,273,007.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,804,026,378.00	4,581,819,015.86
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,520,523,400.00	2,756,868,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,520,523,400.00	2,756,868,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	283,502,978.00	1,824,950,815.86
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	208,703,978.00	268,222,415.86
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,749,000.00	35,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,050,000.00	1,521,428,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,994,739,968.98	10,471,145,843.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,994,739,968.98	10,471,145,843.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,689,993,759.98	7,133,266,565.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	469,833,750.23	542,402,458.00
210101	Үндсэн цалин	465,833,750.23	542,402,458.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,306,418.78	70,791,079.81
210201	Тэтгэврийн даатгал	47,941,047.25	70,501,279.81
210205	Эрүүл мэндийн даатгал	6,182,685.76	289,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,096,633.00	67,085,485.50
210301	Гэрэл, цахилгаан	7,423,719.00	8,840,415.50
210302	Түлш, халаалт	44,213,334.00	55,748,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,459,580.00	2,496,570.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,196,349.00	47,119,286.17

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	157,000.00	8,930,750.00
210402	Тээвэр, шатахуун	8,070,954.30	33,480,451.81
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,464,894.70	4,327,784.36
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	503,500.00	380,300.00
2105	Нормативт зардал	546,486,230.42	4,903,957,386.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	546,486,230.42	4,903,957,386.47
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,230,300.00	29,778,555.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	150,000.00	8,598,155.00
210604	Урсгал засвар	2,580,300.00	21,180,400.00
2107	Томилолт, зочны зардал	9,432,000.00	9,608,500.00
210702	Дотоод албан томилолт	9,432,000.00	9,608,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,469,072.59	6,516,663.50
210803	Даатгалын үйлчилгээ	1,434,420.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	142,438.00	150,738.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,531,414.59	3,693,125.50
210807	Газрын төлбөр	117,800.00	117,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	528,943,005.96	1,456,007,151.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	526,445,112.65	1,412,556,761.44
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,120,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,497,893.31	42,330,389.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,304,746,209.00	3,337,879,278.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,304,746,209.00	3,306,967,800.69
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	732,551,403.00	652,334,821.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	566,796,526.00	1,281,021,108.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,398,280.00	1,373,611,871.69
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	30,911,477.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	30,911,477.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>183,677,504.52</u>	<u>462,333,094.84</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>183,677,504.52</u>	<u>462,333,094.84</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,054,008.66	82,865,460.22	-43,278,902.24	391,640,566.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,054,008.66	82,865,460.22	-43,278,902.24	391,640,566.64
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,048,499.35	15,048,499.35
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	394,748,008.66	662,269,162.96	400,545,997.19	1,457,563,168.81
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	394,748,008.66	662,269,162.96	400,545,997.19	1,457,563,168.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	394,748,008.66	662,269,162.96	400,545,997.19	1,457,563,168.81
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	463,283,094.84	463,283,094.84
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	394,748,008.66	662,269,162.96	863,829,092.03	1,920,846,263.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,806,798,858.00	4,581,819,015.86
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,806,798,858.00	4,581,819,015.86
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,520,523,400.00	2,756,868,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,520,523,400.00	2,756,868,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	286,275,458.00	1,824,950,815.86
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	211,476,458.00	268,222,415.86
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,749,000.00	35,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,050,000.00	1,521,428,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,788,060,043.82	4,578,248,180.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,788,060,043.82	4,578,248,180.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,483,313,834.82	1,235,368,902.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	474,175,540.07	532,622,736.00
210101	Үндсэн цалин	314,873,201.07	332,318,356.00
210102	Нэмэгдэл	77,523,775.00	124,123,662.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,719,445.00	27,195,396.00
210104	Урамшуулал	43,059,119.00	48,985,322.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,457,916.83	70,233,990.00
210201	Тэтгэврийн даатгал	46,526,316.83	51,981,090.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,334,900.00	5,014,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,836,700.00	3,710,800.00

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	959,200.00	1,002,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,800,800.00	8,524,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,761,646.00	67,212,215.50
210301	Гэрэл, цахилгаан	8,033,307.00	8,840,415.50
210302	Түлш, халаалт	44,213,334.00	55,748,500.00
210303	Цэвэр, бохир ус	4,515,005.00	2,623,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,783,870.92	37,683,794.34
210401	Бичиг хэрэг	5,333,900.00	7,615,750.00
210402	Тээвэр, шатахуун	14,657,941.50	21,313,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,689,779.42	4,234,344.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,519,800.00	1,160,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,582,450.00	3,360,200.00
2105	Нормативт зардал	348,523,000.00	20,107,314.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	348,036,800.00	18,186,504.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	486,200.00	1,920,810.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,340,630.00	20,405,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,019,800.00	1,320,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,970,630.00	2,610,100.00
210604	Урсгал засвар	29,350,200.00	16,475,000.00
2107	Томилот, зочны зардал	9,432,000.00	9,608,500.00
210702	Дотоод албан томилолт	9,432,000.00	9,608,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,771,991.56	11,932,338.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,434,420.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	142,438.00	150,738.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,834,333.56	9,108,800.00
210807	Газрын төлбөр	117,800.00	117,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	448,067,239.44	465,562,914.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	448,067,239.44	464,442,914.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,120,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,304,746,209.00	3,342,879,278.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,304,746,209.00	3,311,967,800.69
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	732,551,403.00	652,334,821.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	566,796,526.00	1,281,021,108.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,398,280.00	1,378,611,871.69
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	30,911,477.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	30,911,477.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>18,738,814.18</u>	<u>3,570,835.85</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	3,220,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	3,220,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	3,220,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	3,220,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-3,220,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,738,814.18	350,835.85
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	269,164.15	269,164.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлтүүд	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,756,868,200.00	2,726,285,886.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,756,868,200.00	2,726,285,886.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	795,173,700.00	791,669,957.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	534,173,400.00	532,622,736.00
210101	Үндсэн цалин	333,325,700.00	332,318,356.00
210102	Нэмэгдэл	110,113,800.00	124,123,662.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,735,000.00	27,195,396.00
210104	Урамшуулал	49,998,900.00	48,985,322.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,008,400.00	70,233,990.00
210201	Тэтгэврийн даатгал	48,949,500.00	51,981,090.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,014,700.00	5,014,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,011,800.00	3,710,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,002,900.00	1,002,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,029,500.00	8,524,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,819,500.00	67,212,215.50
210301	Гэрэл, цахилгаан	9,249,500.00	8,840,415.50
210302	Түлш, халаалт	55,748,000.00	55,748,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,822,000.00	2,623,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,733,000.00	37,683,794.34
210401	Бичиг хэрэг	4,550,000.00	7,615,750.00
210402	Тээвэр, шатахуун	24,972,600.00	21,313,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,882,100.00	4,234,344.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,714,500.00	1,160,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,613,800.00	3,360,200.00
2105	Нормативт зардал	20,577,000.00	20,107,314.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,577,000.00	18,186,504.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	1,920,810.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,688,600.00	21,055,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,980,000.00	1,970,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708,600.00	2,610,100.00
210604	Урсгал засвар	16,000,000.00	16,475,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,396,000.00	9,608,500.00
210702	Дотоод албан томилолт	10,396,000.00	9,608,500.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,118,000.00	11,932,338.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	257,400.00	150,738.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,984,800.00	9,108,800.00
210807	Газрын төлбөр	117,800.00	117,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22659800.00	21213970.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,659,800.00	20,093,970.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,120,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1961694500.00	1934615929.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,961,694,500.00	1,934,615,929.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	686,770,800.00	652,334,821.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,274,183,700.00	1,281,021,108.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	740,000.00	1,260,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,756,868,200.00	2,726,016,722.69
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,756,868,200.00	2,726,016,722.69
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,756,868,200.00	2,726,016,722.69
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	269,164.15
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37.00	37.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,824,950,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,824,950,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		444,538,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	444,538,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,380,411,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,375,340,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,375,340,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		5,071,800.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		5,071,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1,824,950,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,824,950,800.00

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		268,222,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		35,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,521,428,400.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан аймгийн эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрүүл мэндийн газар нь харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудыг удирдан зохион байгуулж эрүүл мэндийн бодлого зохицуулалтаар ханган, гүйцэтгэлийг тайлагнах, үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлгээ өгөхтэй холбогдсон үйл ажиллагаа, харилцааг зохицуулна. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийн талаар тавих зорилт, стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлно гэсэн үзүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 771.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 10,470.2 сая төгрөгийн 1.5 хувь буюу 157.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг түүний 75 хувь буюу 117.8 сая төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
АВЛАГА	23,370.74	17,066.20	6.30
БАРАА МАТЕРИАЛ	376,593.91	829,288.10	(452,694.19)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,057,329.35	1,074,491.97	(17,162.62)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,457,563.17	1,920,846.26	(463,283.09)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,457,563.17	1,920,846.26	(463,283.09)

Авлага дансны үлдэгдэл 6.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны авлагын төлөлттэй холбоотой байна.

Бараа материалын данс 12,990.5 мянган төгрөгөөр өссөн нь цаг үеийн шаардлагаар эм боох материал үнэ төлбөргүй нийлүүлэлттэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,162.62 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө худалдан авсан болон үнэгүй шилжүүлэн авсан хөрөнгөтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 463,283.09 мянган төгрөгөөр өссөн нь ковидтой холбоотой үнэ төлбөргүй орлого их хэмжээгээр хүлээн авсантай холбоотойгоор тайлант үеийн үр дүн өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,756,868.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,756,868.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,756,868.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,725,956.7 мянган төгрөгийг зарцуулж, 30,911.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Завхан аймгийн Засаг даргын тамгын газраас 35,300.0 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн яамнаас эрүүл мэндийн ажилчдын тэтгэмж бусад зардалд 1,521,428.4 мянган төгрөгийн, НҮБ болон ДЭМБ-ын төсөл хөтөлбөрийн 268,222.4 мянган нийт 1,824,950.8 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлсэн.

Нэмэлт орлогоос эрүүл мэндийн газар болон эмнэлэг эрүүл мэндийн төвийн албан хаагчдын урамшуулал тэтгэмжид 1,375,600.0 мянган төгрөгийг, төсөл хөтөлбөрийн төсвийн дагуу 268,222.4 мянган төгрөгийг, Сангийн яаманд 5,000.0 төгрөгийг буцаан төвлөрүүлж, 176,068.4 мянган төгрөгийн зарцуулалтыг зориулалтын дагуу хийж 60.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Ковидтой холбоотой Эрүүл мэндийн яам болон бусад холбогдох газруудаас ирсэн эм, нэг удаагийн хамгаалах хэрэгслийг хуваарийн дагуу зарцуулаагүй материалын үлдэгдэл өндөртэй, нягтлан бодох бүртгэлд худалдан авсан зарим бараа материалыг тусган харуулдаггүй мөнгөн сууриар бүртгэл хөтлөлтийг хийж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 122 мэдээлэл, хугацаа хоцроосон 27 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэхэд шилэн дансанд мэдээлэл байршуулахдаа хугацаа хоцроосон байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагад ашиглагдаж байгаа хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 241,280.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 164.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 45,530.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 195,585.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

4.2 Төлбөрийн акт

Бичиг хэргийн ажилтанд үндэслэх баримтгүйгээр 110.8 сая төгрөгийн илүү цагийн хөлс, 54.0 мянган төгрөгийн албан томилот олгосныг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн.

4.3 Албан шаардлага

2021 онд Эрүүл мэндийн яамнаас ирсэн нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, эм тариаг холбогдох газруудад цаг тухайд нь хуваарилаагүй. Эрүүл мэндийн яам болон Аймгийн Засаг даргаас өгсөн албан даалгаврын дагуу ковидын бараа материалын нөөц бүрдүүлсэн боловч тооцоолол, үндэслэлгүйгээр их хэмжээгээр хуримтлуулсан байна. Энэ нь аймаг, хөдөөгийн нэгдсэн эмнэлгүүд, сумдын эрүүл мэндийн төвүүд төсвөөс эм, нэг удаагийн хамгаалах хэрэгслийн худалдан авалтыг хийж төсвийг үрэлгэн зарцуулахад хүргэсэн байна гэж үзлээ. Эрүүл мэндийн газар нь орон тооны нярав томилон ажиллуулдаггүй, мэргэжилтнүүд няравын ажлыг давхар гүйцэтгэж байгаагаас санхүү болон бусад хэлтэс, нэгжүүдийн хооронд мэдээллийн солилцоо муу явагдаж байна. Эм, нэг удаагийн хамгаалах хэрэгслийн үлдэгдлийн хэмжээ их байгаа нь хугацаа дуусах, чанарын шаардлага хангахгүй байх эрсдэл бий болгож байгаа бүрдүүлсэн нөөцөөс бусад үлдэгдлийг цаг хугацаанд нь эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хуваарилж байхыг албан шаардлагаар үүрэг болголоо.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 45,530.8 мянган төгрөгийн зардлыг бараа материалын дансаар дамжуулаагүй, бараа материалын тайланд тусгаагүй байна

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;
- ✓ Зардлыг бараа материалын дансаар дамжуулан зарцуулж хэвших, няраваар бараа материалын тайланг үнэн зөв гаргуулах, хяналт тавьж тооцоо бодсон баримтыг үйлдэж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Эрүүл мэндийн газар	4	241,280.9			2	164.8	1	195,585.3	1	45,530.8
	Нийт дүн	4	241,280.9			2	164.8	1	195,585.3	1	45,530.8